

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

Огноо: 2023.02.08

№ 23/09.

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлийн 47.3, 76 дугаар зүйлийн 76.1.12 дэх заалт, 80 дугаар зүйлийн холбогдох заалтууд, Банкны тухай хуулийн 29, 35 дугаар зүйл, Богд банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 22/125 тоот тогтоолын арван дөрөвдүгээр хавсралтаар баталсан Богд Банк ХК-ийн Ногдол ашгийн журам, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хурлыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- “Богд Банк” ХК нь 2022 оны 2-р хагас жилийн санхүүгийн урьдчилсан байдлаарх татварын дараах цэвэр ашиг болох 11,096,397,566.86 төгрөгийн 25% болох 2,774,099,391.72 төгрөгийн ногдол ашгийг нийт эргэлтэд байгаа 1,250,000,000 ширхэг хувьцаанд тооцон мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
- Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн дүнг 2.2193 төгрөг байхаар тогтоосугай.
- Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
- Ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж болон Үнэт цаасны компаниудаар дамжуулан эрх бүхий этгээдийн зөвшөөрөл шийдвэр ирснээс хойш 60 хоногийн дотор ногдол ашгийг хуваарилсугай.
- Энэхүү тогтоолыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх Захирал /Г.Саруул/-д үүрэг болгосугай:
- Тогтоолын хувийг Монголбанк, Санхүүгийн Зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Саруул)-д даалгасугай.
- Ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Саруул)-д даалгасугай.
- Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга (Л.Болдхуяг)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Огноо: 2023.02.08

№ 03/10

Улаанбаатар хот

ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг  
шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2, 81.3, 81.4, Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.7, Монголбанкны өрөнхийлөгчийн 2022 оны А-143 дүгээр тушаалаар батлагдсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ын 3.1.1, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 03 сарын 23-ний 145 тоот тогтоолоор батлагдсан Компанийн засаглалын Кодекс-ын заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг хавсралтын дагуу шинэчлэн баталсугай.
- Энэхүү тогтоолын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн мөрдөн ажилласугай.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг журмын дагуу идэвхтэй ажиллуулахыг Хороодын дарга наарт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Л. БОЛДХУЯГ



Богд Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн  
23/10 тоот тогтоолын Хавсралт



**Эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүн:**

Хорооны дарга: Э.Бямбажав /ТҮЗ-ийн Хараат бус гишүүн/

Гишүүд: Л.Болдхуяг /ТҮЗ-ийн дарга/

Г.Саруул /ТҮЗ-ийн гишүүн/

Д.Моломжамц /ТҮЗ-ийн гишүүн/

Ж.Нарантуяа /ТҮЗ-ийн Хараат бус гишүүн/

**Аудитын хорооны бүрэлдэхүүн:**

Хорооны дарга: Э.Бямбажав /ТҮЗ-ийн Хараат бус гишүүн/

Гишүүд: Л.Болдхуяг /ТҮЗ-ийн дарга/

Д.Моломжамц / ТҮЗ-ийн гишүүн/

Ж.Нарантуяа /ТҮЗ-ийн Хараат бус гишүүн/

Рожер Томас Моеэс /ТҮЗ-ийн хараат бус гишүүн/

**Нэр дэвшүүлэх, үнэлгээ урамшууллын хорооны бүрэлдэхүүн:**

Хорооны дарга: Ж.Нарантуяа /ТҮЗ-ийн Хараат бус гишүүн/

Гишүүд: Жан Торстен /ТҮЗ-ийн гишүүн/

Эллиот Аукланд /ТҮЗ-ийн гишүүн/

Л.Болдхуяг /ТҮЗ-ийн дарга/